



**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ЯАМ**

**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД
ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН ТӨЛӨВЛӨГӨӨТ БУС
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2026 он

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД ИРГЭНИЙ ӨРГӨДЛИЙН ДАГУУ ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 02 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр баталсан “Биеийн тамир, спортын улсын хорооны үйл ажиллагаатай холбоотой иргэний гаргасан гомдлын дагуу дотоод хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд холбогдох санхүүгийн баримт материал цуглуулан, дүн шинжилгээ хийн, дүгнэлт гаргах зорилгоор дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэлээ.

ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ТОГТООГДСОН БОДИТ НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нэг. М.Гэрэлээ нь гомдолдоо “Монголын хүүхдийн спортын VIII наадамд шаардагдах нэмэлт зардал гаргах тухай 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/191 дүгээр тушаалыг тус наадам дууссанаас хойш 14 хоногийн дараа гаргасан байна гээд энэ тушаалын хавсралтаар баталсан зардал бүрийг тодруулж тайлбар бичиж гомдол ирүүлсэн” -ийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж шалгалаа.

1.1 “Спортын төв ордны гаднах баганад байршуулах хулдаасан хэвлэлийн зардалд 115.2 м.кв талбайд 2,764.8 мянган төгрөгийг зарцуулсан байна. Спортын төв ордны гаднах мэдээллийн самбар 2 ширхэг байдаг, нэг самбар нь 18 м.кв талбайтай, хэвлэлийн компаниуд 1 м.кв-ыг 16.0 мянган төгрөгөөр хэвлэдэг, нийт хэвлэлийн зардал 576.0 мянган төгрөг болно. Иймд 2,288.8 мянган төгрөгийг илүү зарцуулсан тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх шаардлагатай гэсэн байна. Мөн хулдаасан хэвлэлийг баганад тогтоох крантай машины зардал 600.0 мянган төгрөг зарцуулсан, үүнийг тогтооход крантай машинд зардал гаргахгүй, хулдаасан хэвлэл тогтооход техникч н.Эрдэнэ-Очир, Э.Хүрэлчулуун, М.Наранбадрах, Д.Мөнхбаяр нар хийдэг ажил тул 600.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх шаардлагатай” гэсэн гомдлын хянаж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо:

1.1.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтийн баталгаажуулсан тус хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн, “Арт болор принт” ХХК-ны захирал Г.Ганзориг нарын хооронд 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан ажил гүйцэтгэх 160 дугаар гэрээний дагуу хулдаасан хэвлэлийн зардалд 2,764.8 мянган төгрөгийг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр зарцуулсан байна.

1.1.2 Ажил гүйцэтгэх гэрээний 2.1-д Улаанбаатар хотод 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулах “Монголын хүүхдийн спортын зуны VIII наадам”-ын хулдаасан хэвлэлтийг чанарын өндөр түвшинд бэлтгэж, спортын төв ордны гаднах баганад байршуулна гэж тохирсон.

- 1.1.3 Хулдаасан хэвлэлийн ажил гүйцэтгэсэн “Арт болор принт” ХХК-ийн ирүүлсэн үнийн саналд хулдаасан хэвлэлийн өндрийн тогтоолт, буулгалтын зардлыг 691.2 мянган төгрөгөөр гүйцэтгэхээр санал болгосон байна.

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНД

Үнийн санал:

Нэр, үзүүлэлт	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Бүгд
Хулдаас А2	115.2 м2	13000 ₮	1,497,600 ₮
Хулдаас олстой бөгжлөн	115.2 м2	5000 ₮	576,000 ₮
Өндрийн тогтоолт, буулгалт	115.2 м2	6000 ₮	691,200 ₮

Нийт

2,764,800 ₮

- 1.1.4 Спортын ордны гадна баганад байршуулсан хулдаасан хэвлэлийн тогтоолт буулгалтын зардал “Арт болор принт” ХХК-ийн ирүүлсэн үнийн саналд багтсан боловч өндөр ажиллах авто кран шаардлагатай болсон тул 600.0 мянган төгрөгийн нэмэлт зардалд гарч 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдөр олгосон.

- 1.1.5 Хулдаасан хэвлэлийн зах зээлийн үнэ ханшийг судлан БГД-ийн модны 2-т байрладаг Хишиг принт ХХК /утасны дугаар 91373223/ -ийн үнийн саналыг авахад нэг м.кв -ын хэвэлийн үнэ, бэхэлгээний олс, бөгжлөх зардлын хамт 14.3 мянган төгрөгөөр хийх боломжтой байна. Зах зээлийн үнийн судалгаа хийхгүй худалдан авснаар 429.1 мянган төгрөгийн илүү зардал гаргаж, төсвийн хөрөнгийг хэмнэлтгүй зарцуулсан гэж дүгнэв.

- 1.2 Тэмцээний нээлтийг хийх үеэр “300 ширхэг сандал тээвэрлэх түрээсийн зардалд худал төсөв гаргасан тул 900.0 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх шаардлагатай” гэсэн гомдлыг хянан шалгалаа.

- 1.2.1 Биеийн тамир, спортын улсын хорооны төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн данснаас сандал тээвэрлэх зардалтай холбоотой дараах 2 удаагийн гүйлгээ хийгдэж 900.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

- Хүүхдийн наадмын сандлын түрээсийн төлбөрт 350.0 мянган төгрөгийг иргэн Г.Батжаргалын харилцах дансанд 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр төлсөн.
- Мөн иргэн С.Солонгогэрэлд хүүхдийн наадам гэсэн утгатай 550.0 мянган төгрөгийг 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр төлсөн.

- 1.2.2 Хүүхдийн спортын VIII наадмын хаалтын үйл ажиллагааг Спортын төв ордны гадна талбайд хийх болсон тул Буян-Ухаа спорт цогцолбороос 300 ширхэг сандал тээвэрлэсэн Маяти маркийн автомашины төлбөрийг иргэн Г.Батжаргалын харилцах дансанд 350.0 мянган төгрөгийг “Хүүхдийн наадмын сандлын түрээсийн төлбөр” гэсэн утгатайгаар 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр төлсөн байна.

- 1.2.3 Спортын төв ордноос сандлыг буцаан хүргэх ажлыг Жудо бөхийн холбоо хариуцаж портер маркийн 2 автомашинаар зөөхөд 550.0 мянган төгрөг

зарцуулсан. Наадмын хаалтад хэрэглэсэн сандлыг “Шигшээ багийн бэлтгэл сургалтын төв” ТӨҮГ-аас үнэ төлбөргүй ашиглуулсан байна.

- 1.2.4 Гүйлгээ хийсэн санхүүгийн баримтад сандал зөөж тээвэрлэсэн автомашины болон сандлын фото зургийг баримтаар хавсаргасан.
- 1.2.5 Буянт ухаа спорт ордноос Спортын төв ордон хүртэлх зайнд 300ш сандал тээвэрлэх зардлыг зах зээлийн бодит үнээр төсөвлөн зарцуулсан эсэхийг нотлох баримт хангалтгүй байна.
- 1.2.6 Илэрсэн зөрчлөөс дүгнэхэд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн зарчмыг мөрдөж ажиллаагүй байна.

1.3 Хүүхдийн наадмын *“Сайн дурын ажилтан гэдэг нь Олон улсад сайн дураараа нийгмийн идэвхтэй хүний хийдэг ажил. Гэтэл манай Монгол Улсад сайн дурын ажилтнаар дамжуулан бизнес хийгээд байгаа. Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн С.Ундрам байнга хариуцаж хийгээд байгаа. Иймд 8 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлэх шаардлагатай”* гэсэн гомдлыг хянан шалгалаа.

- 1.3.1 Биеийн тамир, спортын улсын хорооны төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн данснаас Хүүхдийн спортын VIII наадамд сайн дурын ажилтнаар ажилласан 10 хүүхдэд тус бүр 800.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгоход нийт 8.0 сая төгрөгийг зарцуулсан.
- 1.3.2 Сайн дурын ажилтан хүүхдүүд цахим төлбөрийн системээр нэхэмжлэл үүсгэн ажлын хөлсөө авсан тул байгууллагын санхүүгээс хувь хүнд олгосон орлогоос татвар суутгах шаардлагагүй, орлогын татварыг төлбөр хүлээн авсан хүн өөрсдөө хариуцах эрхзүйн зохицуулалттай болно.
- 1.3.3 Сайн дурын ажилтны ажлын тайлан бичсэн илтгэх хуудсанд “Уг наадмын шигшээ тэмцээнийг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд сайн дурын 10 хүүхэд ажиллаж 10 хоногийн турш бидний ажилд гүн туслалцаа үзүүлж, идэвхтэй чин сэтгэлээсээ оролцож, бодит туслалцаа үзүүлэн ажилласан” тухай дурдагджээ.
- 1.3.4 Гадаад харилцаа, мэдээллийн технологийн хэлтсийн дарга Н.Оюунбат сайн дурын ажилтан хүүхдүүдийг ахалж ажилласан ба Бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн С.Ундрам энэ ажлын хэсэгт оролцоогүй байна.

1.4 Хүүхдийн наадамд *“60 хүнд 3.6 сая төгрөгийн катерингийн үйлчилгээ авсан нь Хэмнэлтийн тухай хууль зөрчихөөс гадна хулгай гэж харагдаж байгаа тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх шаардлагатай”* гэсэн гомдлыг хянан шалгалаа.

- 1.4.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтийн баталгаажуулсан тус хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн, “Прайм энхесүдэй” ХХК-ны захирал Т.Энхбаяр нарын хооронд 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан үйлчилгээ гүйцэтгэх 158 дугаар гэрээний дагуу катерингийн зардалд 3,600.0 мянган төгрөгийг зарцуулжээ.
- 1.4.2 Гэрээний урьдчилгаа төлбөрт 2,520.0 мянган төгрөгийг 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн үлдэгдэл төлбөр 1,080.0

мянган төгрөгийг байгууллагын нэмэлт санхүүжилтийн данснаас 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдөр гүйлгээ хийж төлбөрийн тооцоо дууссан.

1.4.3 Гүйлгээ хийсэн санхүүгийн баримтад катерингийн үйлчилгээний хоол, ширээ засалтын фото зургийг баримтаар хавсаргасан байна.

1.4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 15.1 Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглох зардалд катерингийн үйлчилгээний зардал ороогүй байна.

1.5 Хүүхдийн наадмын бассейн түрээсийн талаар *“Төв бассейнтэй байгуулсан гэрээг харах шаардлагатай, тэмцээн нь 3 өдөр болохгүй, яагаад гэвэл оролцогч өсвөрийн тамирчин оролцсоноос гадна усан спорт өөрөө хэмжигдэхүүнтэй спортын төрөл учраас 1 өдөр тэмцээн хангалттай амждаг тул 2.5 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх шаардлагатай, уг тэмцээн БГД-ийн БТСГ-ын усан спортын сургалтын төвд зохион байгуулагдсан”* гэсэн гомдлыг хянан шалгалаа.

1.5.1 Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтийн баталгаажуулсан тус хорооны Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга Ж.Баасансүрэн, “Төв бассейн” ХХК-ны захирал Н.Хишигбаяр нарын хооронд 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан үйлчилгээ гүйцэтгэх 151 дүгээр гэрээний дагуу түрээсийн зардалд 3.0 сая төгрөгийг зарцуулжээ.

1.5.2 Гэрээний дагуу 3.0 сая төгрөгийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр нэхэмжлэл, гэрээ дүгнэсэн актыг үндэслэн байгууллагын нэмэлт санхүүжилтийн данснаас 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр гүйлгээ хийсэн.

1.5.3 Баянгол дүүргийн 15 дугаар хорооны нутагт байрлалтай Биеийн тамир, спортын хорооны спорт зааланд уралдаан тэмцээн явуулах нөхцөлийг хангах зорилгоор Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-нд хандан дулаан хангамжийн шугам тоноглолд хийх 2025 оны засварын ажлын хуваарийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрөөс 06 дугаар сарын 02-ны хооронд зохицуулах тухай хүсэлтийг Биеийн тамир, спортын улсын хорооны 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 3/454 дүгээр албан бичгээр хүргүүлсэн байна.

1.5.4 Дулаан хангамжийн засварын ажлын хуваарьт зохицуулалт хийх боломжгүй болсон тул “Төв бассейн” ХХК-тай гэрээ байгуулжээ.

1.5.5 Усан спортын тэмцээнд оролцогч цөөн боловч нэг тамирчин олон төрөлд оролцдог онцлогтой тул тэмцээн хооронд тамирчинд амрах, сэргээлт авах боломжийг олгох стандартын хугацааг баримтлан тэмцээний 3 хоногийн хугацаанд зохион байгуулсан тухай тайлбарыг мэргэжилтэн Э.Хүрэлчулуун өгсөн.

Хоёр. М.Гэрэлээ нь гомдолдоо *“Шилэн данснаас хэд хэдэн хууль бус тушаалтай танилцлаа гэвч агентлагийн нягтлан бодогч Б.Оюунцэцэг нь шилэн дансны мэдээлэл бүрэн гүйцэд оруулаагүйгээс нотлох баримт дутмаг байгаагаас үүдэлтэй танай байгууллагад гомдол гаргаж шалгуулж чадахгүй байдалд хүрээд байгааг уламжилж, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллахыг шаардаж байна”* -гэснийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянаж шалгалаа.

- 2.1 БТСУХ нь 2025 оны эцсийн байдлаар шилэн дансанд 23 нэр төрлийн мэдээллийг 172 талбарт мэдээлэхээс хуулийн хугацааг 2 удаа хоцроож мэдээлсэн, бусад мэдээллийн хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.
- 2.2 Гомдолд хөндсөн Шилэн дансны тухай хуулийн дагуу цахим хуудсанд “хөрөнгө мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг мэдээлэх эрх, үүргийн хэрэгжилтийг шалгахад байгууллагын даргын 2025 онд 375 тушаал баталснаас хөрөнгийн зардал гаргасан тушаал 244, иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан гэрээ хэлцэл 96 байна..
- 2.3 Байгууллагын шилэн дансны цахим хуудсанд 335 тушаал, 96 гэрээг мэдээлснийг тулган шалгахад 64 тушаалыг давхардуулан мэдээлсэн, мэдээлээгүй тушаал байхгүй байна.
- 2.4 Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.10. цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг **холбогдох шийдвэрийн хуулбарын** хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор мэдээлэх зохицуулалттай. Энэ заалтын дагуу 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй зарлагын гүйлгээний холбогдох шийдвэр буюу гүйлгээ хийхдээ үндэслэсэн гэрээ, тушаалын хуулбарыг бүрэн мэдээлсэн байна.

ДҮГНЭЛТ

Дотоод хяналт шалгалтаар Монголын хүүхдийн спортын VIII наадмыг зохион байгуулахтай холбоотой нэмэлт зардлын гүйцэтгэлийн санхүүгийн баримт, тайлан, тайлбарыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хянан үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдлоо. Үүнд:

1. Хулдаасан хэвлэлийн зардал, сандал зөөх тээврийн хөлсний зах зээлийн бодит үнэлгээ, үнийн харьцуулсан судалгаа, тооцоолол хангалтгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4-д заасан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулах зарчимтай нийцэхгүй;
2. Сайн дурын ажилтны урамшууллын зардал, Катерингийн үйлчилгээний зардлын анхан шатны баримт, ажлын тайланг бүрэн, гомдолд дурдсан албан тушаалтан уг ажлыг хариуцаагүй нь тогтоогдсон тул гомдолд хөндсөн асуудал нотлогдоогүй;
3. Усан спортын тэмцээн зохион байгуулахаар төлөвлөсөн анхны байршил тодорхой шалтгаанаар тэмцээн явуулах боломжгүй нөхцөл үүсэж, “Төв бассейн” ХХК-тай гэрээ байгуулсан нь албан бичиг, тайлбараар нотлогдсон ба тэмцээнийг 3 хоног зохион байгуулсан үндэслэл нь спортын онцлог, стандарт хугацаатай нийцэж байгаа тул гомдол дурдсан зөрчил тогтоогдоогүй;
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад байгууллагын шилэн дансанд “хөрөнгө мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр”-ийг хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг хангаж мэдээлсэн байна.

Монголын хүүхдийн спортын VIII наадмыг зохион байгуулахтай холбоотой Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2025 оны А/191 дүгээр тушаалаар нэмэлтээр гаргасан 18.9 сая төгрөгийн зардлууд нь санхүүгийн анхан шатны баримт, гэрээ, гүйцэтгэлийн актаар нотлогдсон боловч хулдаасан хэвлэлийн зардал, сандал зөөх тээврийн хөлс төлсөн зардалд зах зээлийн үнийн судалгаа хийгээгүй байдлаас шалтгаалан 429.1 мянган төгрөгийн илүү зардал гаргаж Төсвийн тухай хуулийн 6.4-д заасан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөж зарцуулах зарчмыг баримтлаагүй, гэрээ баталгаажуулалтын шатанд дотоод хяналт сул байна.

ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

Дотоод хяналт шалгалтын дүнгээр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, дотоод хяналтыг сайжруулан ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Билэгтэд даалгаж байна.

Зөвлөмж 1. Зах зээлийн үнийн судалгаа, үнийн саналын харьцуулалтыг хийхдээ 2 ба түүнээс дээш үнийн санал авч баталгаажуулдаг тогтолцоог мөрдүүлэх, түрээс, тээврийн үйлчилгээний зардалд жишиг тариф ашиглах;

Зөвлөмж 2. Гэрээ ба үнийн саналд багтсан ажлын задаргааг санхүү, дотоод хяналтын ажилтан, нэгжээр хянуулах, үнийн саналд багтсан зардлуудыг гэрээнд тодорхой тусгах;

Зөвлөмж 3. Сайн дурын ажилтанд урамшуулал олгох журам батлах, спортын их дээд сургуультай хамтран ажиллах гэрээ байгуулан, сургуулийн саналаар оюутан, залуучуудыг сонгон ажиллуулах, тэдний гүйцэтгэх ажлын даалгавар, цагийн бүртгэл, үр дүнгийн тайланг маягтаар хөтөлж санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг сайжруулах, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэг цагийн хөлснөөс дээш дүнгээр ажлын хөлсийг цагаар тооцон олгох;

1. Дотоод хяналт шалгалтын дүгнэлтэд үндэслэн өгсөн зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлэн биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт ирүүлэх.

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМ

---оОо---